

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДАЛ

2020

Мониторингийн тайлан



Тайлан боловсруулсан

Хүрэлчулууны Баярмаа
Ахлах судлаач

Даринчулууны Нарантуяа
Судлаач

Эрдэнэбатын Цэрэндорж
Судлаач

Мэдээлэл цуглуулагч

Болдын Болор
Дата судлаач




Түвшинтөрийн Пүрэв-Очир

Бадамцэцэгийн Баясгалан

Гантулгын Булганчимэг

“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал 2020:
Мониторингийн тайлан”-г IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн
санаачилгаар 9 дэх жилдээ хийж гүйцэтгэв.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ СУДАЛГААНЫ ӨМНӨХ ТАЙЛАНГУУД



* Зураг бүр дээр дарж тайлан тус бүртэй танилцах боломжтой. Нийт тайлан: <http://irim.mn/web-monitoring>

АГУУЛГА

Оршил	5
Арга зүй	7
Индексийн зорилго, зорилт Бүтэц, арга зүй Үр дүнгийн онооны тайлбар Хамрах хүрээ	
Үр дүн	10
Улсын түвшинд	10
Цахим ил тод байдлын өөрчлөлт	
Байгууллагын түвшинд	13
Яамдын цахим ил тод байдал	
Хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал	
Тохируулагч агентлагийн цахим ил тод байдал	
Аймгийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдал	
Дүүргийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдал	
Парламентын харьяа байгууллагын цахим ил тод байдал	
Дүгнэлт, санал зөвлөмж	21
Дүгнэлт	
Санал зөвлөмж	
Хавсралт 1. Цахим ил тод байдлын индексийн бүтэц	23
Хавсралт 2. Нийт төрийн байгууллагын эрэмбэ	24
Хавсралт 3. Цахим хуудасны ил тод байдлыг үнэлэх шалгуурууд	27

ОРШИЛ

Төрийн тухай үзэл баримтлал нь орчин үед иргэдийн ашиг сонирхлыг “төв” болгон төрийн үйл ажиллагааг тэдэнд ойртуулах, төрөөс иргэдтэй харилцах харилцааг сайжруулахад чиглэгдэж, энэ нь технологийн дэвшилттэй хослон хөгжиж байна. Манай улсын хувьд ч “сайн засаглал”-ыг цахим дэвшилтэй нийцүүлэн төлөвшүүлэх хөтөлбөр, хууль дүрмийг 2004 оноос эхлэн гарган баталж, хэрэгжүүлэх болсон. Хамгийн сүүлийн байдлаар гэхэд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг 2020 онд баталсан. Түүний тавдугаар бүлэг болох “Засаглал”-ын зорилго нь *“Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр - хувийн хэвшил - иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно”* гэж тодорхойлжээ. Цахим технологид тулгуурласнаар Засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах, мэдээллийн чөлөөт урсгал нэмэгдэх боломж бүрддэг бол нөгөө талаар иргэд аливаа мэдээлэл, үйлчилгээ нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авах боломж бүрддэгээрээ давуу талтай.

Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор баталсан Төрийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Илтод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” (2009) болон “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” (2011) хуулийн дагуу одоогоор төрийн захиргааны бүх байгууллагууд мэдээллийн ил тод байдлын талаар тайлан мэдээллээ гарган нийтэлж байгаа ч энэ нь тодорхой стандартаар хэмжигдэх, харьцуулагдах боломж муу байна.

Тиймээс IRIM судалгааны хүрээлэн нь 2010 оноос хойш дээрх хууль дүрмийн хэрэгжилтийг үнэлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилготойгоор төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг үнэлж ирсэн. Энэхүү мониторинг нь дээр дурдсанчлан төрийн байгууллагуудын цахим хуудас хэрхэн сайжирч, эсвэл хэрхэн муудаж буйг тоон утга харгалзуулан жил жилээр үнэлэх, мөн бусад байгууллагатай харьцуулж болохуйцаар эрэмбэ тогтоон цахим хуудасны мэдээллийг тогтмол сайжруулахад нь хөшүүрэг болох үндсэн зорилготойгоор хэрэгждэг. Харин 2019 онд уг үнэлгээг олон улсын түвшний индекс болгох зорилго өвөрлөн судалгааны аргазүйгээ шинэчилж, төрийн байгууллагын **‘Цахим ил тод байдлын индекс’**-ийг боловсруулж, туршсан. 2020 оны COVID-19 цар тахлын нөхцөл байдлаас үүдэн индексийн аргазүйгээр мэдээлэл цуглуулах хязгаарлагдмал байдал үүссэн учир индексийн аргазүй дээр тулгуурлан энэхүү **‘Төрийн байгууллагуудын цахим ил тод байдал-2020’** мониторингийн тайлангийн ажлыг гүйцэтгэв.¹

Энэхүү тайлан нь Монгол Улсын төрийн болон нутгийн захиргааны нийт 86 байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлыг үнэлж, гарсан үр дүнг өнгөрсөн онтой харьцуулах байдлаар байгууллага бүрийн цахим хуудасны ил тод байдлын өнөөгийн нөхцөлийг тодорхойллоо. Тус үнэлгээгээр төрийн байгууллагуудыг хооронд нь харьцуулж байгаа ч энэ нь тэдгээрийн ил тод байдлыг бүрэн илэрхийлэхүйц үнэмлэхүй хэмжүүр биш гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй. Уг үр дүнгээр төрийн байгууллага өөрсдийн эсвэл бусад төрийн байгууллага бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээхэд гарч буй ололт ба бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлээр баримталж буй бодлого, стратегийг сайжруулахад ашиглаж болно.

¹ Цахим ил тод байдлын индексийн бүтцийг Хавсралт 1-с харна уу.

Ил тод байдал гэж юу вэ?

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтоор ил тод байдал гэдэг нь “төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь найдвартай, холбогдолтой, цаг үеийн байдлаар олон нийтэд хүрч байгааг хэлнэ” (OECD 2011). Харин НҮБ-ын ази, номхон далайн эдийн засаг ба Нийгмийн комисс: “Ил тод байдал гэдэг нь төрөөс гаргаж буй шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь уг шийдвэрийн нөлөөлж буй хэнд ч чөлөөтэй, хүртээмжтэй байхыг хэлнэ” гэжээ (UNESCAP 2011).

Цахим ил тод байдал гэж юу вэ?

Цахим ил тод байдал гэдэг нь мэдээллийг цахим хэлбэрээр нээлттэй, хүртээмжтэй хүргэхийг хэлнэ. Орчин үеийн мэдээлэл харилцааны технологи (МХХТ)-ийг ашиглах нь ил тод байдлыг бүхэлд нь сайжруулах суурь хүчин зүйл болдог. Цахим засаглалын хамгийн тохиромжтой хэлбэр нь засгийн газрын бүх салбар, нэгж хоорондоо харилцан уялдаатай ажиллаж, иргэн, аж ахуйн нэгжүүдэд нэг цонхоор, тэгш үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Энэ утгаараа МХХТ-ийн хөгжлийн хамгийн чухал хэсэг нь газар зүйн байршлаас үл хамааран төрийн байгууллагын ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийг сурталчлахад хувь нэмэр оруулж байдаг. Нэгдсэн Үндэсний Байгууллагын 2018 оны цахим засаглалын судалгааны тайланд цахим хэрэглээ нь нийгмийн оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний зардлыг багасгадаг болохыг тогтоожээ. Тиймээс дижиталчлал нь төрийн шийдвэр гаргалт дахь иргэний орон зай ба оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах нь гарцаагүй юм.

Түүнчлэн уг арга зүй нь төрийн байгууллага, тэдгээрийн нэгжүүдийн цахим мэдээлэл түгээхтэй холбоотой асуудалд түлхэц үзүүлэх, ил тод ба нээлттэй байх соёлыг хөгжүүлэхэд цахим мэдээллийн ил тод байдал хэрхэн чухал үүрэг гүйцэтгэдгийг мэдээлэх үүрэгтэй юм. Үр дүнг төрийн удирдлага, цахим засаглал, ил тод байдал, МХХТ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хэн боловч ашиглах боломжтой.

АРГА ЗҮЙ

Индексийн зорилго, зорилт

Цахим ил тод байдлын индексийн зорилго нь төрийн байгууллагуудын цахим мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг үнэлж, тоон үзүүлэлтээр хэмжин, цаашид сайжруулахад хувь нэмэр оруулах явдал юм.

Цахим ил тод байдлын индексээр цахим хэрэгслээр нээлттэй болгож буй мэдээллийн хэмжээ, цар хүрээг үнэлнэ. Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн агуулга нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” болон “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” ЗГ-ын тогтоол, бусад холбогдох дүрэм журамтай хэр нийцэж байгаад төвлөрнө.

Ач холбогдлын хувьд уг индекс нь төрийн байгууллагын цахим засаглалыг бүхэлд нь үнэлдэг цор ганц индекс юм. Индексийн гол онцлог нь:

- Зөвхөн цахим ил тод байдлын нээлттэй мэдээллийг үнэлэх
- Өнгөрсөн онтой харьцуулагдахуйц байх
 - Ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх
 - Цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах юм.

Бүтэц, арга зүй

Цахим ил тод байдлын индекс нь нэгдмэл нэг оноогоор илэрхийдэгдэх бөгөөд 3 бүрэлдэхүүн хэсэг, 9 дэд бүлэг, 26 индикатораас бүрдэнэ. Индикатор бүр дотроо хэд хэдэн асуултуудаас бүрдэнэ. Энэхүү мониторингийн тайлан нь 3-р бүрэлдэхүүн хэсэг буюу *Цахим нээлттэй байдал* гэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд гүйцэтгэв.¹

Цахим нээлттэй байдал нь *Технологи, Нээлттэй мэдээллийн агуулга, Иргэдийн оролцоо ба харилцаа* гэсэн 3 дэд бүлгээс бүрэлдэнэ. Үүнд:

Технологи – Тухайн цахим хуудаст хандалт хийхэд хялбар нэвтэрч байгаа эсэх болон хайлтын систем, хэлний сонголт гэх мэт үзүүлэлтээр хэмжсэн.

Нээлттэй мэдээллийн агуулга – Тухайн байгууллагын бүтэц, холбоо барих мэдээллүүд болон хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх холбогдох хуульд заасан мэдээллүүд байгаа эсэх. Мөн статистик болон бусад нээлттэй өгөгдлүүдийг ашиглах боломжтой эсэхийг багтаасан.

Иргэдийн оролцоо ба харилцаа – Хандалт болон ямар нэг байдлаар харилцах боломжтой байгаа эсэхийг хэмжих зорилготой шалгуурууд багтсан.

Цахим нээлттэй байдлын дэд бүлэг, индикаторуудын задаргаа болон жингийн тооцооллыг доорх хүснэгтээс харах боломжтой.

¹ Цахим ил тод байдлын индексийн бүтцийг Хавсралт 1-с харна уу.

Цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсгийн бүтэц, жин



Цахим нээлттэй байдлын хувьд нийт 45 асуулттай байгаа ба үүнийг задалбал Технологийн бүлэг 6, Нээлттэй мэдээллийн агуулга 36, Иргэдийн оролцоо ба харилцаа 3 асуулттай байна. Ингэснээр эдгээр дэд бүлгүүд тус бүр 0.13 (6/45), 0.8 (33/45) болон 0.07 (3/45) гэж жинлэгдэж байна. Жишээлбэл, Технологи бүлгийн Технологийн нийцтэй байдал дэд бүлгийн хувьд 3 асуултаас бүрдэж байгаа учир 0.07 (3/45) жинтэй байна. Хэрвээ индикатор доторх асуултын тоо өөрчлөгдвөл дээр аргаар жинг хувааж тооцоолно.

Үр дүнгийн онооны тайлбар

Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна. Үр дүнгийн утгыг доорх хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Үр дүнгийн утгын ангилал

Сайн	≥0.80	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой бодлого, баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжилтийг маш сайн хангасан. Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бүрэн бэхжүүлсэн.
Хангалттай	0.65-0.79	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой ихэнх бодлого, баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжилтийг хангасан. Гэхдээ зарим чиглэлд ахиц дэвшил гаргах шаардлагатай. Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бэхжүүлж байгаа.
Сул	0.50-0.64	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой зарим үзүүлэлт байгаа. Үүнийг цаашид нэмэгдүүлэх, байгаа мэдээллүүдийг шинэчлэх, тогтвортой хангах чадавхыг зарим талаар бэхжүүлэх шаардлагатай.
Хангалтгүй	0.35-0.49	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой бодлого, баримт бичиг байхгүй. Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх талаар суурь түвшний процедур, нөөц, хариуцлагатай, ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадвар хомс байна.
Муу	<0.35	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой бодлого, баримт бичиг байхгүй. Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага бараг байхгүй, энэ нь эргээд цахим хуудас/хэрэгслээр мэдээллийг түгээхгүй байхад гол нөлөө үзүүлж байгаа.

Хамрах хүрээ

Төрийн захиргааны түвшний нийт 90 байгууллагыг хамруулж, албан ёсны цахим хуудаст хандалт хийснээс 86 байгууллагын индексийг тооцон гаргасан. Энэ онд шинээр Засгийн газар шинэчлэн зохион байгуулагдсантай холбоотой Соёлын яам, Үндэсний геологийн алба, Эм, эмнэлгийн хэрэгслийнхяналт,зохицуулалтынгазаргэсэн 3 байгууллагын цахим хуудас ашиглалтад ороогүй, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн цахим хуудас засвартай байв.

Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараанийтэлжбуймэдээллийнхэрэгцээ шаардлага, агуулга болон хэрэглэгчдэд

хүртээмжтэй байдлыг “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” болон бусад холбогдох дүрэм журамтай нийцүүлж үнэлсэн. Түүнчлэн технологийн нийцтэй ба үр ашигтай байдлыг харгалзан үзэв.

Мөн тусгай үүргийн буюу Батлан хамгаалах яам, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах газар, Зэвсэгт хүчний жанжин штаб гэх мэт тусгай үүргийн, зарим мэдээллүүд нь нууцлалтай байх байгууллагуудын хүний нөөцийн мэдээлэл зэргийг үнэлгээнд хасаж тооцсон.

Үнэлгээний мэдээлэл цуглуулалт буюу цахим хуудаст хандсан хугацаа нь 2020 оны 12-р сард хийгдсэн.

ЗУРАГ 3

Үр дүнгийн утгын ангилал



ҮР ДҮН


Улсын түвшинд

Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн захиргааны 86 төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үр дүнг нэгтгэн тооцлоо. Нийт 13 яам, 22 хэрэгжүүлэгч агентлаг, 12 тохируулагч агентлаг, 21 аймгийн засаг даргын тамгын газар, 9 дүүргийн засаг даргын тамгын газар, 9 парламентын харьяа байгууллагууд хамрагдсан. Цахим ил тод байдлын ерөнхий үр дүн улсын хэмжээнд **0.537** гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сул түвшинд үнэлэгдлээ. Үүнийг өнгөрсөн онтой харьцуулахад (0.518) бага хэмжээгээр өссөн мэт боловч тийм ч мэдэгдэхүйц өөрчлөлт гарсангүй.

Үнэлгээнд хамрагдсан 86 байгууллагаас 15 хувь нь буюу 13 байгууллага л ил тод 'хангалттай' түвшинд байгаагаас ердөө 2 байгууллага нь "сайн" түвшинд байна. Нийт байгууллагын тал хувь нь болох 42 байгууллага сул түвшинд үнэлэгджээ. Үлдсэн байгууллагуудын 24 нь "хангалтгүй" түвшинд, 7 байгууллага нь "муу" түвшинд үнэлэгдсэн байна.


Тиймээс цаашид цахим ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Үүнийг индикатор тус бүрээр өнгөрсөн онтой харьцуулахад ямар өөрчлөлттэй байгааг дараах хүснэгтээс харна уу.



ЗУРАГ 4

Байгууллагуудын ил тод байдлын түвшинд эзлэх хувь



ХҮСНЭГТ 1

Цахим ил тод байдлын нэгдсэн үр дүн

#	Үзүүлэлтүүд	2019	2020	Өөрчлөлт
	Технологи	0.598	0.529	0.449
1	Технологийн нийцтэй байдал	0.749	0.684	-0.065
2	Технологийн үр нөлөөтэй байдал	0.447	0.374	-0.073
	Нээлттэй мэдээллийн агуулга	0.403	0.534	0.131
3	Үйл ажиллагаа	0.715	0.599	-0.116
4	Хүний нөөцийн бодлого	0.439	0.438	-0.001
5	Төсөв, санхүү	0.507	0.653	0.146
6	Худалдан авах ажиллагаа	0.320	0.426	0.106
7	Нээлттэй өгөгдөл	0.639	0.608	-0.031
	Иргэдийн оролцоо ба харилцаа	0.523	0.591	0.068
8	Харилцаа ба эгэх холбоо	0.523	0.591	0.068
	Цахим ил тод байдлын үр дүн	0.518	0.537	0.019

*Үр дүнгийн онооны тайлбар: Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

Индикатор тус бүрээр нь авч үзвэл 8 индикатораас 4 индикатор нь өнгөрсөн жилтэй харьцуулахад буурсан, 1 индикатор хэвэндээ, 3 индикатор өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрээс зөвхөн 2 индикатор (технологийн нийцтэй байдал ба төсөв санхүү) “хангалттай” түвшинд үнэлэгдсэн бол үлдсэн индикаторууд “сул” ба хангалтгүй түвшинд үнэлэгджээ. Харин технологийн үр нөлөөтэй байдал хамгийн хангалтгүй байна.

Бүрэлдэхүүн тус бүрээр нь тодруулбал:

Технологийн шийдэл “сул” түвшинд үнэлэгдсэн. Төрийн байгууллагуудын цахим хуудас ямар ч веб хөтөч болон хэрэгслийн хувьд нийцэн ажилладаг, хайхад хялбархан олддог, хурд нь боломжийн түвшинд байна. Харин цахим хуудаснаас мэдээллийг хайж олох, гадаад хэлний сонголт, мэдээллийг гадаад хэл дээр нийтлэх асуудал хангалтгүй байна.

Нээлттэй мэдээллийн агуулга мөн “сул” түвшинд үнэлэгдсэн. Төрийн байгууллагуудын нийтлэх ёстой мэдээллийн агуулгын хувьд төсөв санхүүгийн мэдээлэл хамгийн сайн буюу “хангалттай” түвшинд байна. Энэнь “Шилэндансны тухай хууль”-аар зохицуулагдаж, хяналт тавьж ажилладагтай холбоотойгоор гүйцэтгэл сайн байна.

Үүний дараа нээлттэй өгөгдөл буюу тухайн байгууллага цахим хуудас дээрээ байршуулсан ашиглаж болохуйц тоо баримт, мэдээ, мэдээлэл байгаа эсэх, түүнийг татаж авах боломж дунд түвшинд байна. Харин, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хүний нөөц, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл “хангалтгүй” байна.

Иргэдтэй харилцах боломжийн тухайд цахим хуудсаараа иргэдийн санал гомдлыг хүлээн авах, хариу өгч шийдвэрлэх явдал өнгөрсөн жилтэй харьцуулахад өссөн боловч “хангалтгүй” түвшинд байсаар байна.

Цахим ил тод байдлын өөрчлөлт

IRIM судалгааны хүрээлэн нь 2018 оноос өмнө төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг хэмжихдээ хувиар тооцон гаргадаг байв. Ингэхдээ шалгуур үзүүлэлт бүрийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг “Хаалттай”, “Зарим талаар ил тод”, “Ил тод”, “Бүрэн ил тод” гэсэн 4 түвшингээр үнэлж ирсэн. Харин 2019 оноос эхлэн ‘Цахим ил тод байдлын индекс’-ийг болгон өөрчилсөн ч индексийн цахим хуудас үнэлэх үр дүнг хувиар шилжүүлэн тооцож, өмнөх жилүүдтэй харьцуулах боломжтой юм. Ингээд доорх хүснэгтэд нэгтгэсэн үр дүнг харъя.

ЗУРАГ 5

Хамрагдсан төрийн байгууллагын төрлүүд, тоо



Эх сурвалж: Төрийн байгууллагын цахим хуудасны ил байдлын мониторинг, IRIM судалгааны хүрээлэн

IRIM судалгааны хүрээлэн нь цахим хуудасны мониторинг хийснээс хойш арван жилийн хугацаанд төрийн байгууллагуудын цахим хуудасны мэдээллийн агуулга, хүртээмж жилээс жилд сайжирсан бөгөөд үүний үр дүн нь төрийн байгууллагуудыг цахим хуудсаа сайжруулах гол хөшүүрэг болсон юм. Анх 2010 онд судалгаанд хамрагдсан 81 төрийн байгууллагын цахим хуудны ил тод байдал ердөө 17.7 хувьтай байв. Энэ нь 2009 онд төрийн байгууллагын “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг батлаад дөнгөж нэг жилийн хугацаа өнгөрч байсан.

Үүний дараа 2011 онд нэмэгдэж 28.7 хувьд хүрсэн ч хангалтгүй хэвээр байв. Энэ байдал 2015 оноос дээрдэж 50 орчим хувьтай “зарим талаар ил тод” болсон ч сүүлийн 5 жилийн хугацаанд төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал төдийлөн өссөнгүй. Төрийн байгууллагуудын цахим хуудас иргэдэд нээлттэй мэдээллүүдийг оруулах зорилго бүхий цэсүүдийг байршуулсан ч доторх мэдээллийг тогтмол шинэчилдэггүй, мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг нийтлэг дутагдлууд ажиглагдсаар байна.

Байгууллагын түвшинд

Энэ хэсэгт үр дүнг байгууллагын түвшинд авч үзнэ. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээнд дараах 6 төрлийн байгууллагыг жил бүр хамруулж үр дүнг гаргаж ирсэн. Өмнөх жилүүдэд эдгээр 6 төрлийн байгууллагын нийт тоо дунджаар 81 байдаг байсан бол 2020 оны хувьд 90 болсон нь байгууллагуудын чиг үүрэг улам нарийсаж, салбарлаж байгааг харуулж байна.

Нийт байгууллагын үр дүнг харахад ихэнх байгууллагын ил тод байдал өнгөрсөн онтой харьцуулахад өсжээ.

Эдгээр байгууллагуудаас Тохируулагч агентлагийн үр дүн өнгөрсөн онтой харьцуулахад буурсан бол 3 төрлийн байгууллагын үр дүн өссөн, үлдсэн хоёр нь мэдэгдэхүйц өөрчлөлтгүй байна. Үнэлгээнд хамрагдсан 86 байгууллагыг цахим ил тод байдал нь эрэмбэлэн жагсаахад Дархан-Уул аймгийн ЗДТГ (0.811), Өвөрхангай аймгийн ЗДТГ (0.800), Улсын бүртгэлийн ерөнхий газар (0.733) эхний 3 байрт тус тус жагсаж байна.² Хэдийгээр эхний байруудад ороогүй ч Дорнод аймгийн ЗДТГ, Цаг уур орчны шинжилгээний газар, Барилга хот байгуулалтын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газруудын цахим ил тод байдал өнгөрсөн онтой харьцуулахад хамгийн сайн өсөлттэй байна.

Үүнийг байгууллагын төрөл тус бүрээр нарийвчлан дараагийн хэсгүүдэд дэлгэрүүлнэ.

ХҮСНЭГТ 2

Үр дүн, байгууллагын ангиллаар

#	Байгууллагын төрөл	2019	2020	Өөрчлөлт
1	Дүүргүүдийн Засаг даргын тамгын газар	0.551	0.542	-0.009
2	Монгол улсын яамд	0.532	0.534	0.002
3	Парламентын харьяа байгууллагууд	0.474	0.522	0.048
4	Аймгуудын Засаг даргын тамгын газар	0.529	0.576	0.047
5	Хэрэгжүүлэгч агентлагууд	0.521	0.557	0.036
6	Тохируулагч агентлагууд	0.496	0.444	-0.052
Ерөнхий дундаж		0.518	0.537	0.019

***Үр дүнгийн онооны тайлбар:** Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

² Нийт байгууллагуудын үр дүнгийн оноог Хавсралтаас харна уу.

Яамдын цахим ил тод байдал

Нийт 13 яамны цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад яамдын үр дүн өөрчлөлтгүй байна. Яамны ангилал дотроо ХХААХҮЯ 0.753 оноогоор өнгөрсөн жил тэргүүлж байсан бол 2020 онд Зам тээврийн яам 0.689 оноогоор тэргүүлжээ. Энэ нь “хангалттай” түвшинд үнэлэгдэж буй ганц яам болж байна. Ихэнх яамд “сул” түвшинд үнэлэгдэж байгаа бол 4 яамны цахим ил тод байдал хангалтгүй түвшинд байна.

Яамдыг өнгөрсөн онтой харьцуулахад ЗТХЯ, ХЗДХЯ, БХБЯ, БШУЯ зэрэг яамд өсөлттэй, ЭМЯ, БОАЖЯ, өөрчлөлтгүй бусад яамд бууралттай гарчээ.³

Яамдын хувьд цахим ил тод байдалд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ХҮСНЭГТ 3

Үр дүн, яамдаар

Эрэмбэ / Ранк	Яам	Оноо
1	Зам, тээврийн хөгжлийн яам	0.689
2	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	0.611
3	Сангийн яам	0.589
4	Хууль зүй, дотоод хэргийн яам	0.589
5	Эрчим хүчний яам	0.589
6	Эрүүл мэндийн яам	0.567
7	Барилга, хот байгуулалтын яам	0.533
8	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	0.522
9	Боловсрол, шинжлэх ухааны яам	0.511
10	Батлан хамгаалах яам	0.489
11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	0.444
12	Гадаад харилцааны яам	0.422
13	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	0.389
Яамдын дундаж оноо		0.534
Монгол Улсын нэгдсэн оноо		0.537

*Үр дүнгийн онооны тайлбар: Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

Давуу тал	Сул тал
Бүх яамны цахим хуудас нь технологийн хувьд нийцэл сайтай буюу ямар ч веб хөтөч болон хэрэгслээс хандах бүрэн боломжтой	Гадаад хэл дээрх мэдээллүүд хангалтгүй.
Бүх яамны цахим хуудсыг хайж олоход маш хялбар. Ихэнх яамны цахим хуудас “вэбсайтын бүтэц” буюу мэдээллийг хялбар олох зорилго бүхий хэсэгтэй	Хүний нөөцийн талаарх мэдээллүүд сайн боловч, хэлтсийн дарга болон холбогдох албан тушаалтантай холбогдох мэдээлэл хангалтгүй.
Байгууллагуудын ажилтнуудад цахим платформуудыг ашиглах боломж хангалттай нээлттэй байдаг	Төсөв санхүүгийн мэдээлэл сайн боловч, худалдан авах ажиллагааны талаарх холбогдох мэдээлэл хангалтгүй.
Байгууллагаас гаргасан шийдвэртэй холбоотой мэдээллийг ил тод нийтэлдэг. Бүх холбогдох тогтоол, журмыг цахим хуудаснаас харж болно.	Цахим хуудсан дээр иргэдтэй шууд харилцах, тэдний санал, гомдлыг хүлээн авах хэсэг байхгүй
Мэдээ, мэдээллийг байнга шинэчилдэг. Холбогдох мэдээллийг татаж авах боломжтой байдаг.	Веб сайтад хандсан хүний тоо байхгүй.

³ Батлан хамгаалах яам өнгөрсөн жил оролцохоос татгалзсан учир харьцуулагдаагүй. Бусад яамдын үзүүлэлтийн өөрчлөлтийг Хавсралт хэсгээс харна уу.

Хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал

Нийт үйл ажиллагаа явуулж буй 22 хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдлын дундаж 0.557 ба өнгөрсөн онтой харьцуулахад (0.529) бага зэрэг өссөн байна. Хэрэгжүүлэгч агентлагийн ангилал дотроо өнгөрсөн онд Ашигт малтмал, газрын тосны газар 0.718 оноогоор тэргүүлж байсан бол энэ онд Улсын бүртгэлийн ерөнхий газар тэргүүлжээ. Нийт 4 хэрэгжүүлэгч агентлагийн

цахим ил тод байдал хангалттай түвшинд байгаа бол 11 агентлагийн цахим хуудас “сул” түвшинд, үлдсэн 7 хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал “хангалтгүй” түвшинд байна.

Хэрэгжүүлэгч агентлагуудыг өнгөрсөн онтой харьцуулахад ихэнх нь өссөн байна.³ Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ХҮСНЭГТ 4

Үр дүн, хэрэгжүүлэгч агентлагиар

Эрэмбэ / Ранк	Яам	Оноо
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	0.733
2	Татварын ерөнхий газар	0.700
3	Ашигт малтмал, газрын тосны газар	0.689
4	Оюуны өмчийн газар	0.689
5	Гадаадын иргэн, харьяатын газар	0.644
6	Иргэний нисэхийн ерөнхий газар	0.611
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	0.611
8	Архивын ерөнхий газар	0.589
9	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	0.589
10	Мал эмнэлгийн ерөнхий газар	0.567
11	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.567
12	Нийгмийн даатгалын ерөнхий газар	0.556
13	Цаг уур, орчны шинжилгээний газар	0.556
14	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	0.533
15	Усны газар /Ус сувгийн удирдах газар/	0.522
16	Төрийн худалдан авах ажиллагааны газар	0.489
17	Жижиг, дунд үйлдвэрийн газар	0.478
18	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	0.478
19	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	0.456
20	Соёл урлагийн газар	0.422
21	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	0.400
Хэрэгжүүлэгч агентлагуудын дундаж оноо:		0.557
Монгол Улсын нэгдсэн оноо		0.537

*Үр дүнгийн онооны тайлбар: Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

Давуу тал	Сул тал
Төсөв санхүү болон худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг байршуулах байдал сайн.	Ихэнх байгууллагын цахим хуудсанд байгууллагын хэлтсийн дарга нарын нэр, утасны жагсаалт хангалттай бус, байршуулаагүй.
Үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээлэл хангалттай.	Гадаад хэл дээрх мэдээлэл хангалтгүй.
Статистик мэдээлэл болон судалгааг байршуулах байдал хангалттай.	Дотоод хайлтын систем хангалтгүй. Ихэнх байгууллагад байхгүй.
Ихэнх агентлагууд ажлын байрны зарыг тогтмол мэдээлэлдэг	Цахим хуудасны бүтэц хэсэг байхгүй учир мэдээлэл олоход хүндрэлтэй.
Нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоос бүх агентлагуудын цахим хуудсанд багтсан	Цахим хуудас дээрх иргэдтэй харилцах, санал гомдол авах хэсэг зарим байгууллагын хувьд хангалтгүй.

Тохируулагч агентлагийн цахим ил тод байдал

Нийт үйл ажиллагаа явуулж буй 12 тохируулагч агентлагуудын цахим ил тод байдлын дундаж (0.444) улсын дунджаас бага байгаа ба өнгөрсөн онтой (0.496) харьцуулахад бага зэрэг буурсан байна. Тохируулагч агентлагийн ангилал дотроо Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар өнгөрсөн онд 0.674 оноогоор тэргүүлж байсан бол энэ онд Үндэсний хөгжлийн газар тэргүүлжээ. Нийт тохируулагч агентлагийн хувьд “хангалттай” түвшинд үнэлэгдсэн агентлаг байхгүй, “сул”, “хангалтгүй” түвшинд байна.

Тохируулагч агентлагуудын дундаж оноо өнгөрсөн онтой харьцуулахад Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Үндэсний хөгжлийн газрын үнэлгээ өссөн. Эсрэгээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын үнэлгээ буурсан. Бусад агентлагуудын оноо мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй байна.⁴ Тохируулагч агентлагуудын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ХҮСНЭГТ 5

Үр дүн, тохируулагч агентлагийн

Эрэмбэ / Ранк	Яам	Оноо
1	Үндэсний хөгжлийн газар	0.622
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	0.611
3	Цагдаагийн ерөнхий газар	0.611
4	Онцгой байдлын ерөнхий газар	0.556
5	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	0.522
6	Хил хамгаалах ерөнхий газар	0.489
7	Стандарт, хэмжил зүйн газар	0.433
8	Биеийн тамир, спортын улсын хороо/	0.422
9	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	0.400
10	Зэвсэгт хүчний жанжин штаб	0.333
11	Тагнуулын ерөнхий газар	0.189
12	Төрийн тусгай хамгаалалтын газар	0.144
Тохируулагч агентлагуудын дундаж оноо:		0.444
Монгол Улсын нэгдсэн оноо		0.537

*Үр дүнгийн онооны тайлбар: Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

⁴ Үзүүлэлтийн өөрчлөлтийг ХАВСРАЛТ хэсгээс харна уу.

Давуу тал	Сул тал
Бусад төрийн байгууллагуудын цахим хуудас руу орох холбоосыг нэгээс бусад бүх агентлагууд өөрийн цахим хуудсандаа байршуулсан	Цахим хуудасны бүтцийн хэсэг байхгүй, түүнчлэн гадаад хэл дээрх мэдээллүүд хангалтгүй
Цахим хуудсанд ямар ч хөтчөөс хандах боломжтой	Дотоод хайлтын систем ихэнх агентлагт байхгүй.
Порталын агуулга хангалттай	Холбогдох хэлтсийн дарга, албан тушаалтны мэдээлэл ихэнх агентлаг байршуулаагүй.
Ихэнх агентлагууд тусгай эсвэл нэгдсэн сервертэй	Вэбсайт дээрээ статистик мэдээлэл болон үйлчилгээний талаарх бүртгэлийн тоо баримт оруулдаггүй.
	Шууд харилцах боломжит хэрэгсэл ихэнх агентлагт байхгүй.

Аймгийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдал

Нийт 21 аймгийн засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ын цахим ил тод байдлын дундаж үнэлгээг (0.576) улсын дундажтай (0.537) харьцуулахад өндөр байгаа бөгөөд өнгөрсөн жилээс (0.535) өссөн байна. Аймгийн ЗДТГ-ын ангилал дотроо 2019 онд Дундговь аймгийн ЗДТГ 0.774 оноогоор тэргүүлж байсан бол 2020 онд Дархан-Уул аймгийн ЗДТГ 0.811 оноогоор тэргүүлжээ. Нийт 7 аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдал сайн болон хангалттай түвшинд

байгаа нь бусад төрийн байгууллагатай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Энэ нь аймгийн ЗДТГ нь бусад төрийн захиргааны байгууллагуудтай харьцуулахад тогтвортой бүтэцтэй байдагтай холбоотой гэж үзэж байна. Гэвч 6 аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдал хангалтгүй байгааг дурдах хэрэгтэй.

Аймгуудын цахим ил тод байдал 2019 оноос нэмэгдсэн аймгууд нь Дорнод, Дархан-Уул, Өмнөговь бол буурсан үзүүлэлттэй нь Сүхбаатар, Увс, Сэлэнгэ, Архангай зэрэг аймгууд байна.⁵ Аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ХҮСНЭГТ 6

Үр дүн, аймгийн ЗДТГ-аар

Эрэмбэ / Ранк	Яам	Оноо
1	Дархан-Уул аймгийн ЗДТГ	0.811
2	Өвөрхангай аймгийн ЗДТГ	0.800
3	Өмнөговь аймгийн ЗДТГ	0.733
4	Дундговь аймгийн ЗДТГ	0.722
5	Говь-Алтай аймгийн ЗДТГ	0.711
6	Орхон аймгийн ЗДТГ	0.700
7	Хэнтий аймгийн ЗДТГ	0.656
8	Дорнод аймгийн ЗДТГ	0.644
9	Булган аймгийн ЗДТГ	0.633
10	Дорноговь аймгийн ЗДТГ	0.622
11	Хөвсгөл аймгийн ЗДТГ	0.622
12	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	0.578
13	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	0.556
14	Завхан аймгийн ЗДТГ	0.556
15	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	0.556
16	Төв аймгийн ЗДТГ	0.478
17	Архангай аймгийн ЗДТГ	0.456
18	Баянхонгор аймгийн ЗДТГ	0.422
19	Увс аймгийн ЗДТГ	0.356
20	Ховд аймгийн ЗДТГ	0.333
21	Сүхбаатар аймгийн ЗДТГ	0.156
Аймгийн ЗДТГ-ын дундаж оноо:		0.576
Монгол Улсын нэгдсэн оноо		0.537

***Үр дүнгийн онооны тайлбар:** Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

Давуу тал	Сул тал
Ямар ч төрлийн хөтөч, хайлтын системээс төвөггүй нэвтрэх боломжтой.	Гадаад хэлний сонголт байхгүй. Гадаад хэл дээрх мэдээлэл, сайтын цэс байхгүй.
Байгууллагын бүтэц болон холбогдох албан тушаалтнуудын мэдээллийг байршуулах байдал сайн.	Аливаа хэрэгцээт мэдээлэл, нээлттэй өгөгдлийг татах боломжгүй.
Төсөв, санхүү болон худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллүүдийг нээлттэй ил тод байршуулах байдал бусад байгууллагатай харьцуулахад өндөр.	Шууд харилцах боломж бүхий хэсэг байхгүй.
Орон нутгаас гаргаж буй шийдвэрүүдийг тухай бүрд нийтэлдэг.	7 аймгийн цахим хуудаст хандсан хүний тоог харах боломжгүй байна.

⁵ Үзүүлэлтийн өөрчлөлтийг Хавсралт хэсгээс харна уу.

Дүүргийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдал

Нийт 9 дүүргийн Засаг даргын тамгын газрын цахим ил тод байдлын дундаж үнэлгээг (0.542) өнгөрсөн жилтэй (0.551) харьцуулахад мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна. Дүүргийн ЗДТГ-ын ангилал дотроо 2019 онд Чингэлтэй дүүргийн ЗДТГ 0.684 оноогоор тэргүүлж байсан бол 2020 онд Сүхбаатар дүүргийн ЗДТГ тэргүүлж,

“хангалттай ил тод” гэж үнэлэгджээ. Нийт 5 дүүргийн ЗДТГ-ын цахим ил тод байдал “сул” түвшинд байгаа бол үлдсэн 3 дүүргийн ЗДТГ-ын цахим ил тод байдал хангалтгүй, муу байна.

Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Багануур дүүргүүдийн ЗДТГ-ын цахим хуудас урьд оныхоос буурсан үзүүлэлттэй байна.⁶ Дүүргийн ЗДТГ-ын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ХҮСНЭГТ 7

Үр дүн, дүүргийн засаг даргын тамгын газраар

Эрэмбэ / Ранк	Яам	Оноо
1	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	0.656
2	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	0.644
3	Налайх дүүргийн ЗДТГ	0.611
4	Хан-Уул дүүргийн ЗДТГ	0.600
5	Багахангай дүүргийн ЗДТГ	0.589
6	Баянгол дүүргийн ЗДТГ	0.589
7	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	0.478
8	Баянзүрх дүүргийн ЗДТГ	0.367
9	Багануур дүүргийн ЗДТГ	0.344
Дүүргүүдийн ЗДТГ дундаж оноо:		0.542
Монгол Улсын нэгдсэн оноо		0.537

***Үр дүнгийн онооны тайлбар:** Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

Давуу тал	Сул тал
Дотоод хайлтын системийг нэгээс бусад цахим хуудаст шийдсэн.	Вэбсайтад хайж буй зүйлийг хялбар олуулах зорилго бүхий сайтын бүтэц хэсэг байхгүй
Байгууллагын бүтэц, хүний нөөцийн талаарх мэдээлэл сайн.	Гадаад хэл дээр мэдээлэл оруулдаггүй.
Төсөв санхүүгийн үзүүлэлтүүдийг хангах байдал сайн.	Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах байдал сул.
Бүх дүүргүүд байгууллагаас гаргасан шийдвэрийн тухай тогтмол мэдээлэлдэг	Нээлттэй өргөдөл, материалыг татаж авах боломж огт хангагдаагүй.
Бусад мэдээ, мэдээллүүдийг тогтмол шинэчилж, цаг тухай бүрд нь нийтэлдэг.	Ямар нэг байдлаар санал, хүсэлт, гомдол гаргах механизм ихэнх дүүргийн цахим хуудаст бүрдээгүй.
Бусад холбогдох нийгмийн сүлжээ рүү холбогдох байдал сайн.	Цахим хуудсаар зочилсон хандалтыг зарим дүүргүүд нээлттэй харуулдаггүй.

⁶ Үзүүлэлтийн өөрчлөлтийг Хавсралт хэсгээс харна уу.

Парламентын харьяа байгууллагын ил тод байдал

Нийт 9 парламентын харьяа байгууллагын цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд дундаж үнэлгээ (0.522) өнгөрсөн жилтэй (0.474) харьцуулахад өссөн байна. Парламентын харьяа байгууллагын ангилал дотроо Монгол банк 0.719 оноогоор 2019 онд тэргүүлж байсан бол энэ онд мөн адил тэргүүлсэн хэдий ч дундаж үнэлгээ буурч "хангалттай" түвшнээс "сул" түвшинд оржээ. Мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын

албаны цахим хуудас ижил үзүүлэлттэй байна. Нийт 5 парламентын харьяа байгууллагын цахим ил тод байдал сул түвшинд байгаа бол үлдсэн 4 байгууллагын цахим ил тод байдал хангалтгүй, муу байна.

Парламентын харьяа байгууллагуудын цахим ил тод байдлыг өнгөрсөн жилтэй харьцуулахад Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба болон Санхүүгийн зохицуулах хорооны үзүүлэлт илт сайжирсан байна. Парламентын харьяа байгууллагуудад дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ХҮСНЭГТ 8

Үр дүн, парламентын харьяа байгууллагаар

Эрэмбэ / Ранк	Яам	Оноо
1	Монгол банк	0.644
2	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	0.644
3	Сонгуулийн ерөнхий хороо	0.611
4	Санхүүгийн зохицуулах хороо	0.578
5	Авлигатай тэмцэх газар	0.533
6	Үндэсний статистикийн хороо	0.467
7	Хүний эрхийн үндэсний комисс	0.456
8	Аудитын газар	0.422
9	Төрийн албаны зөвлөл	0.344
Парламентын харьяа байгууллагуудын дундаж оноо:		0.522
Монгол Улсын нэгдсэн оноо		0.537

***Үр дүнгийн онооны тайлбар:** Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

Давуу тал	Сул тал
Дотоод хайлтын систем ихэнх байгууллагууд шийдсэн.	Хэлтсийн дарга, холбогдох мэдээлэл ихэнх байгууллагуудад байршуулаагүй.
Байгууллагаас гаргасан шийдвэрийн тухай болон бусад мэдээллүүдийг тогтмол шинэчилж, мэдээлэлдэг.	Цахим хуудас дээрх ил тод байдлын хэсэг хангалтгүй, зарим мэдээллүүдийг дутуу оруулсан.
Нийгмийн сүлжээ рүү холбогдох холбооснуудаа бүх байгууллага байршуулсан.	Цахим хуудас дээр шууд харилцах боломж ихэнх байгууллагад байхгүй.
Дотоод хайлтын систем ихэнх байгууллагууд шийдсэн.	Хэлтсийн дарга, холбогдох мэдээлэл ихэнх байгууллагуудад байршуулаагүй.
Байгууллагаас гаргасан шийдвэрийн тухай болон бусад мэдээллүүдийг тогтмол шинэчилж, мэдээлэлдэг.	Цахим хуудас дээрх ил тод байдлын хэсэг хангалтгүй, зарим мэдээллүүдийг дутуу оруулсан.

Дүгнэлт

Цахим хуудасны ил тод байдал өнгөрсөн жилтэй (0.518) харьцуулахад бага зэрэг нэмэгдсэн ч (0.537) “сул” түвшинд байна. Үүнийг өмнөх жилүүдийн дунджаар аваад үзвэл сүүлийн 5 жил мэдэгдэхүйц өөрчлөлтгүй дунджаар 50 хувьтай байгаа нь цаашид цахим хуудасны ил тод байдлыг нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна.

Цахим хуудаснуудын технологийн нийцтэй байдал нь ерөнхийдөө “хангалттай”, бүхэлдээ ямар ч хөтчөөс (internet explorer, firefox, chrome) хайсан шууд илрэх, мөн Монгол улсын Засгийн газрын цахим хуудсанд (www.zasag.mn) хуудасны холбоосоор шууд холбогдох боломжтой зэрэг нь хэрэглэгчид олоход амар, хялбар байдлыг бий болгож байна. Гэвч технологийн үр нөлөөтэй байдал “хангалтгүй” түвшинд байна. Учир нь зарим байгууллагуудын цахим хуудасны бүтэц байхгүй, дотоод хайлтын систем байхгүй, гадаад хэл дээрх мэдээлэл ордоггүй зэрэг нь тухайн цахим хуудаснаас хэрэгцээт мэдээллийг хялбар олж авахад бэрхшээл учруулж байгаа юм.

Агуулгын хувьд ерөнхийдөө “сул” түвшинд байна. Үйл ажиллагааны талаарх мэдээллийг байршуулах байдал өнгөрсөн оноос буурсан. Энэ нь 2020 онд Засгийн газар шинээр бүрэлдсэнтэй холбоотой, бүтэц зохион байгуулалт, холбогдох

албан тушаалтнуудын талаарх мэдээллүүд тавигдаагүй байгаа үзэгдэл нийтлэг байв. Харин төсөв, санхүүгийн чиглэлээр тавьж буй мэдээлэл нэмэгдэж “хангалттай” түвшинд хүрсэн байгаа нь энэ үзүүлэлтийн гүйцэтгэлийн хянах тогтолцоо бусад үзүүлэлттэй харьцуулахад сайн байдагтай холбоотой гэж үзэж байна. Бусад ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд “хангалтгүй” түвшинд байсаар байна.

Иргэдтэй харилцах боломжийн үзүүлэлт (0.591) өнгөрсөн оноос (0.523) бага зэрэг нэмэгдсэн ч “хангалтгүй” хэвээр байна. Иргэд санал, хүсэлт, гомдлоо цахимаар гаргах боломж болон чат гэх мэт онлайн шууд холбогдох боломж бага байна. Хэдийгээр 2020 он цар тахлын нөлөөгөөр онлайн горимд шилжин ажиллах шаардлага салбар бүрд тулгарч байгаа ч төрийн байгууллагын хувьд цахим хуудсаараа дамжуулан энэ төрлийн шинэчлэлт, хөгжүүлэлтийг хийх байдал сул байгааг харууллаа.

Байгууллагын төрлөөр нь дүгнэвэл Аймгуудын ЗДТГ-ын үзүүлэлт бусдаасаа хамгийн өндөр үнэлгээтэй гардаг нь хамгийн тогтвортой нэгж байдагтай холбоотой. Гэвч аймгуудын дундаж үнэлгээ нь (0.576) сул түвшинд байгаа нь цаашид илүү сайжрах шаардлага бий гэдгийг харууллаа. Харин тохируулагч агентлагийн дундаж үнэлгээ (0.444) сүүлийн хоёр жилд “хангалтгүй” гэсэн түвшинд байна.

Санал зөвлөмж

Үнэлгээний үр дүнд үндэслэн, цаашид байгууллагууд цахим хуудсаа сайжруулахад ашиглах дараах санал зөвлөмжүүдийг хүргэж байна. Үүнд:

- Цахим хуудасны бүтцийн сонголт болон дотоод хайлтын системийг олоход хялбар, ойлгомжтойгоор байршуулах. Энэ нь цахим хуудаснаас мэдээлэл хайж олоход хүндрэлтэй байгаа асуудлуудыг шийдвэрлэнэ.
- Байгууллагууд мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хуульд заагдсан үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой бүх төрлийн нээлттэй мэдээллийг зүйл заалт тус бүртэй нь тулгаж дутуу мэдээллийг нөхөж оруулах, шинэчлэхэд анхаарал хандуулах шаардлагатай. Эдгээр мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа эсэхийг хянах үүрэг бүхий төв байгууллага нь ирүүлсэн тайлан, мэдээллийг тоон утгаар хэмжих, эрэмбэлэх боломжтой байдлаар дүрэм, журмаа боловсруулах нь цаашдын ил тод байдлыг бодитоор нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.
- Хуульд заагдсан буюу хэрэглэгчид авах боломжтой бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ хэлэлцээртэй холбоотой мэдээллийг нээлттэй байршуулах байдал боломжийн хэмжээнд байгаа ч түүнийг ашиглах, татаж авах боломж хомс байна. Тиймээс мэдээллийн бэлэн байдлыг хангаж, ашиглаж болохуйцаар байршуулах хэрэгтэй.
- Мөн тухайн байгууллагатай холбоотой үйлчилгээний статистик болон үйлчилгээ үзүүлсэн бүртгэлийн тоо баримтыг нийтэлдэг байх нь тухайн чиглэлээрх мэдээллийг сонирхон ашиглах иргэдэд мэдээллийг олж авах байдлыг нь илүү хялбаршуулах давуу талтай.
- Олон нийтийн сүлжээний суваг байгаа бол заавал үүнийг цахим хуудсан дээрээ холбож өгөх шаардлагатай. Ингэснээр хэрэглэгчийн мэдээлэл авах сувгийг нэмж өгнө.
- Цахим хуудас бүрд тухайн байгууллагатай холбоо тогтоох, санал хүсэлт илгээх хэсгийг нээлттэй оруулж өгснөөр хэрэглэгчидтэй харилцах, эгэх хариуцлагыг нэмэгдүүлэхээс гадна цаашдын цахим хуудасны хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэхэд түлхэц болно гэж үзэж байна.
- Хавсралтад бүх байгууллагыг индексийн түвшнээр нь ихээс бага руу эрэмбэлэн оруулсан ба эхэнд эрэмбэлсэн ижил төрлийн байгууллагын цахим хуудаст хандан харилцан суралцах боломжтой юм.

Хавсралт 1. Цахим ил тод байдлын индексийн бүтэц

Цахим ил тод байдлын индекс нь нэгдмэл нэг оноогоор илэрхийдэгдэх бөгөөд энэ нь Эрх зүйн орчин, Байгууллагын чадамж, Цахим нээлттэй байдал гэсэн 3 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь 9 дэд бүлэг, 26 индикатораас бүрдэнэ. Индикатор бүр дотроо тодорхой хэмжээний асуултуудаас бүрдэнэ.



Хавсралт 2. Нийт төрийн байгууллагын эрэмбэ

	Байгууллагын нэр	Байгууллагын төрөл	2019	2020	Өөрчлөлт
1	Дархан-Уул аймаг	Аймгийн ЗДТГ	0.632	0.811	0.179
2	Өвөрхангай аймаг	Аймгийн ЗДТГ	0.79	0.800	0.010
3	Улсын бүртгэлийн ерөнхий газар*	Хэрэгжүүлэгч агентлаг		0.733	0.733
3	Өмнөговь аймаг	Аймгийн ЗДТГ	0.544	0.733	0.189
4	Дундговь аймаг	Аймгийн ЗДТГ	0.724	0.722	-0.002
5	Говь-Алтай аймаг	Аймгийн ЗДТГ	0.556	0.711	0.155
6	Татварын ерөнхий газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.534	0.700	0.166
6	Орхон аймаг	Аймгийн ЗДТГ		0.700	0.700
7	Зам, тээврийн хөгжлийн яам	Яам	0.59	0.689	0.099
7	Ашигт малтмал, газрын тосны газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.631	0.689	0.058
7	Оюуны өмчийн газар*	Хэрэгжүүлэгч агентлаг		0.689	0.689
8	Хэнтий аймаг	Аймгийн ЗДТГ	0.636	0.656	0.020
8	Сүхбаатар дүүрэг	Дүүргийн ЗДТГ	0.589	0.656	0.067
9	Гадаадын иргэн, харьяатын газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.544	0.644	0.100
9	Дорнод аймаг	Аймгийн ЗДТГ	0.144	0.644	0.500
9	Сонгинохайрхан дүүрэг*	Дүүргийн ЗДТГ		0.644	0.644
9	Монгол банк	Парламентын харьяа	0.68	0.644	-0.036
9	Улаанбаатар хотын захирагчийн алба	Парламентын харьяа	0.456	0.644	0.188
10	Булган аймаг	Аймгийн ЗДТГ	0.6	0.633	0.033
11	Үндэсний хөгжлийн газар	Тохируулагч агентлаг	0.501	0.622	0.121
11	Дорноговь аймаг	Аймгийн ЗДТГ	0.634	0.622	-0.012
11	Хөвсгөл аймаг	Аймгийн ЗДТГ	0.623	0.622	-0.001
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Яам	0.756	0.611	-0.145
12	Иргэний нисэхийн ерөнхий газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.73	0.611	-0.119
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.666	0.611	-0.055
12	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Тохируулагч агентлаг	0.546	0.611	0.065
12	Цагдаагийн ерөнхий газар	Тохируулагч агентлаг	0.569	0.611	0.042

12	Налайх дүүрэг	Дүүргийн ЗДТГ	0.502	0.611	0.109
12	Сонгуулийн ерөнхий хороо	Парламентын харьяа	0.558	0.611	0.053
13	Хан-Уул дүүрэг*	Дүүргийн ЗДТГ		0.600	0.600
14	Сангийн яам	Яам	0.622	0.589	-0.033
14	Хууль зүй, дотоод хэргийн яам	Яам	0.389	0.589	0.200
14	Эрчим хүчний яам	Яам	0.767	0.589	-0.178
14	Архивын ерөнхий газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.411	0.589	0.178
14	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.286	0.589	0.303
14	Багахангай дүүрэг	Дүүргийн ЗДТГ	0.579	0.589	0.010
14	Баянгол дүүрэг	Дүүргийн ЗДТГ	0.644	0.589	-0.055
15	Говьсүмбэр аймаг	Аймгийн ЗДТГ	0.544	0.578	0.034
15	Санхүүгийн зохицуулах хороо	Парламентын харьяа	0.445	0.578	0.133
16	Эрүүл мэндийн яам	Яам	0.546	0.567	0.021
16	Мал эмнэлгийн ерөнхий газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.528	0.567	0.039
16	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.623	0.567	-0.056
17	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.505	0.556	0.051
17	Цаг уур, орчны шинжилгээний газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.222	0.556	0.334
17	Онцгой байдлын ерөнхий газар	Тохируулагч агентлаг	0.558	0.556	-0.002
17	Баян-Өлгий аймаг*	Аймгийн ЗДТГ		0.556	0.556
17	Завхан аймаг*	Аймгийн ЗДТГ	0.512	0.556	0.044
17	Сэлэнгэ аймаг	Аймгийн ЗДТГ	0.744	0.556	-0.188
18	Барилга, хот байгуулалтын яам	Яам	0.2	0.533	0.333
18	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.422	0.533	0.111
18	Авлигатай тэмцэх газар	Парламентын харьяа	0.562	0.533	-0.029
19	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Яам	0.523	0.522	-0.001
19	Ус сувгийн удирдах газар*	Хэрэгжүүлэгч агентлаг		0.522	0.522

21	Батлан хамгаалах яам*	Яам		0.489	0.489
21	Төрийн худалдан авах ажиллагааны газар*	Хэрэгжүүлэгч агентлаг		0.489	0.489
21	Хил хамгаалах ерөнхий газар	Тохируулагч агентлаг	0.513	0.489	-0.024
22	Жижиг, дунд үйлдвэрийн газар*	Хэрэгжүүлэгч агентлаг		0.478	0.478
22	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар*	Хэрэгжүүлэгч агентлаг		0.478	0.478
22	Төв аймаг	Аймгийн ЗДТГ	0.295	0.478	0.183
22	Чингэлтэй дүүрэг	Дүүргийн ЗДТГ	0.521	0.478	-0.043
23	Үндэсний статистикийн хороо	Парламентын харьяа	0.455	0.467	0.012
24	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.624	0.456	-0.168
24	Архангай аймаг	Аймгийн ЗДТГ	0.491	0.456	-0.035
24	Хүний эрхийн үндэсний комисс	Парламентын харьяа	0.456	0.456	0.000
25	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Яам	0.456	0.444	-0.012
26	Стандарт, хэмжил зүйн газар	Тохируулагч агентлаг	0.423	0.433	0.010
27	Гадаад харилцааны яам	Яам	0.489	0.422	-0.067
27	Соёл урлагийн газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.443	0.422	-0.021
27	Биеийн тамир, спортын улсын хороо	Тохируулагч агентлаг	0.423	0.422	-0.001
27	Баянхонгор аймаг	Аймгийн ЗДТГ	0.41	0.422	0.012
27	Үндэсний аудитын газар	Парламентын харьяа	0.378	0.422	0.044
28	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар*	Хэрэгжүүлэгч агентлаг		0.400	0.400
28	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	Тохируулагч агентлаг	0.178	0.400	0.222
29	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Яам	0.598	0.389	-0.209
30	Гаалийн ерөнхий газар	Хэрэгжүүлэгч агентлаг	0.769	0.367	-0.402
30	Баянзүрх дүүрэг	Дүүргийн ЗДТГ	0.499	0.367	-0.132
31	Увс аймаг	Аймгийн ЗДТГ	0.569	0.356	-0.213
32	Багануур дүүрэг	Дүүргийн ЗДТГ	0.524	0.344	-0.180
32	Төрийн албаны зөвлөл	Парламентын харьяа	0.276	0.344	0.068
33	Зэвсэгт хүчний жанжин штаб*	Тохируулагч агентлаг		0.333	0.333
33	Ховд аймаг	Аймгийн ЗДТГ	0.312	0.333	0.021
34	Тагнуулын ерөнхий газар*	Тохируулагч агентлаг		0.189	0.189
35	Сүхбаатар аймаг	Аймгийн ЗДТГ	0.404	0.156	-0.248
36	Төрийн тусгай хамгаалалтын газар*	Тохируулагч агентлаг		0.144	0.144

*2019 онд төрийн байгууллагын цахим ил тод байдлыг илүү өргөн хүрээнд үнэлсэн ба эрх зүйн орчин, байгууллагын чадавхыг үнэлэхийн тулд тухайн байгууллагын холбогдох албан хаагчаас үнэлгээнд хамрагдах зөвшөөрөл авч байсан. Үүний дагуу өнгөрсөн онд зарим байгууллагууд үнэлгээнд хамрагдахыг зөвшөөрөөгүй тул өнгөрсөн оны мэдээлэл байхгүй байгууллагуудыг *-оор тэмдэглэв.

Хавсралт 3. Цахим хуудасны ил тод байдлыг үнэлэх шалгуурууд

	Индикатор	Тайлбар/Асуулт	Онооны шалгуур	#
D1. ТЕХНОЛОГИ:	D1.1 Технологийн зохицол Дээд оноо-3	Энэ вэбсайтад ямар ч хөтөч болон хэрэгслээс хандах боломжтой юу?	Энэ вэбсайтад гар утас болон таблет дээр ажилладаг бүх төрлийн хөтчөөс хандах боломжтой эсэх	1
		Энэ вэбсайтыг хайлтын хэрэгсэл, портал дээрээс олоход хялбар байдаг уу?	Хайлтын хамгийн эхэнд эсвэл эхний хуудас дээр гарч ирдэг эсэх	2
		Вэбсайтын өөрийн хурд хэд байна вэ?	https://developers.google.com/speed/pagespeed/insights (90-100; 50-89; 0-49)	3
	D1.2 Технологийн үр нөлөөтэй байдал Дээд оноо - 4	Вэбсайтад хайж буй зүйлийг хялбар олуулах зорилго бүхий сайтын бүтэц хэсэг байна уу?	Байгаа эсэх	4
		Дотоод хайлтын систем эсвэл хэрэгсэл байна уу?	Дэвшилтэт хайлтын хэрэгсэлтэй эсвэл хайлтын хэрэгсэлтэй боловч Google хайлттай шууд холбогдсон учир энэ нь бүх мэдээллийг хайж олох боломжгүй болгож өгдөг	5
		Вэбсайтад гадаад хэл дээрх мэдээллүүд байна уу?	Хэлийн сонголт болон орчуулга байгаа эсэх, бүх хамаарал бүхий мэдээллүүд орчуулагдсан байна.	6
D2. ИЛ ТОД МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА:	D2.1 Мэдээллийн агуулга	Байгууллагын холбоо барих мэдээлэл багтсан	Байрлалын зураг болон газрын зураг бүхий хаяг, утасны дугаар, цахим хаяг, шуудангийн хаяг болон цагийн хуваарь бүгд багтсан эсэх	7
		Байгууллагын бүтцийн тухай мэдээлэл багтсан	Байгууллагын ажилтнуудын нэр, холбогдох утасны дугаар бүхий бүтцийн мэдээлэл багтсан юмуу бүтцийн шатлалыг зөвхөн зургаар харуулсан эсэх	8
		Хэлтсийн дарга нарын нэрс болон холбогдох дугаар багтсан	Байгаа эсэх	9
		Хүний нөөцтэй холбогдол бүхий мэдээлэл багтсан – 7	Ажлын байрны зарыг тогтмол мэдээлэлдэг	10
			Ёс зүйн дүрэм багтсан	11
			Хүний нөөцийн стратеги, түүний хяналт болон зохицуулалтын үнэлгээ багтсан	12
			Ажилтнуудын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтийн үнэлгээний тухай мэдээлэл болон тайлангийн мэдээлэл багтсан	13
			Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын явц болон дүрэм журмын тухай мэдээлэл багтсан	14
			Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын үр дүн болон тайлбар багтсан	15
			Төсвийн ил тод байдлыг хангах тодорхой тусдаа хэсэг байгаа	16
		Төсөв, санхүүтэй холбоотой мэдээлэл багтсан – 10	Тухайн жилийн байгууллагын төсвийн мэдээлэл багтсан	17
			Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө багтсан	18
			Өнгөрсөн жилийн төсвийн зардлын мэдээлэл багтсан	19
			Өнгөрсөн сар бүрийн эсвэл улирал бүрийн төсвийн зардлын мэдээлэл багтсан	20

D2. ИЛ ТОД МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА:	D2.1 Мэдээллийн агуулга	Төсөв, санхүүтэй холбоотой мэдээлэл багтсан – 10	Төсвийн аудитын үр дүн багтсан	21
			Аудитын үр дүнгийн талаар хийсэн хэлэлцүүлэг болон үйл ажиллагааны тухай мэдээлэл багтсан	22
			Төсвийн зардлын өсөлт эсвэл хасалтын тухай тайлбар багтсан	23
			Төсвийн тодотгол багтсан	24
			Үйлчилгээний үнийн мэдээлэл багтсан	25
			Тендерийн урилгын мэдээлэл багтсан	26
			Тендерийн баримт бичиг багтсан	27
			Худалдан авах ажиллагааг үнэлэх дүрэм журам эсвэл явцын мэдээлэл багтсан	28
			Тендерт оролцогчдод тавих шалгуур багтсан	29
			Тендерийн үр дүн болон тайлбар багтсан	30
			Хэрэгжиж дууссан худалдан авах ажиллагааны тайлан багтсан	31
			Хэрэгжиж дууссан худалдан авах ажиллагааны үр дүнд хийсэн аудитын мэдээлэл багтсан	32
			Бонд эсвэл үүнтэй төстэй санхүүгийн өрийг зарах эсвэл худалдаж авах тухай шийдвэрийн мэдээлэл багтсан	33
			Үзүүлж буй үйлчилгээний тухай мэдээлэл багтсан	34
			Байгууллагаас гаргасан шийдвэрийн тухай мэдээлэл багтсан	35
	Хууль, дүрэм журам, тогтоол г.м байгаа эсэх			
	Бусад төрийн агентлагуудын линк буюу сайтуудыг харуулсан	Байгаа эсэх	36	
	Статистик мэдээлэл болон судалгааны үр дүнгүүд багтсан	Байгаа эсэх	37	
	Порталын агуулгын шинэчлэлийг нотлох баримтыг харуулсан	Байгаа эсэх	38	
D2.2 Нээлттэй өгөгдөл		Хэрэв байгууллага ямар нэгэн бүртгэлийн үйлчилгээ явуулдаг бол ашиглах боломжтой нээлттэй өгөгдөл эсвэл эх сурвалжууд байгаа юу?	Байгаа эсэх	39
		Тус нээлттэй өгөгдлийг (бэлэн бус өгөгдөл) татах боломжтой байна уу?	Байгаа эсэх	40
		Энд ямар нэгэн мета өгөгдөл байна уу?	Байгаа эсэх	41
D3. Хэрэглэгчдийн оролцоо ба харилцаа	D3.1 Харилцаа холбоо болон эгэх холбоо	Ямар нэгэн шууд харилцах боломжит хэрэгсэл байна уу?	Байгаа эсэх	42
		Санал хүсэлт болон гомдол гаргах механизм байна уу?	Байгаа эсэх	43
		Ямар нэгэн нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоос байна уу?	Байгаа эсэх	44
		Вэбсайтад хандсан хүний тоо	Байгаа эсэх	45